



Сорьц зөөвөрлөдөг эмнэлгийн ажилтанд зориулсан зөвлөмж

/Эмнэлгийн сувилагч, ажилтан, жолооч
нарт/

Улаанбаатар хот
2025 он

Амьд сорьцын шинжилгээний илгээх бичиг дээр:

- Үйлчлүүлэгчийн овог нэр
- Нас хүйс
- Регистрийн дугаар
- Эмнэл зүйн онош
- Эмнэлэг, тасгийн нэр
- Мэс засалд орсон он сар өдөр
- Сорьцын нэр, төрөл
- Сорьц илгээсэн эмчийн нэр, утасны дугаар
- Эмнэлгийн буцах хаягийг гаргацтай тодорхой бичсэн байна.

Амьд сорьцыг хэрхэн хадгалах вэ?

- Эд муудахаас сэргийлэн бэхжүүлэх уусмал болох 10% формалинд хийнэ
- Хэрвээ эмнэлэгт 24 цаг байлгах болбол гэрлийн тусгалаас хол харанхуй газар хадгална
- Бэхжүүлэх уусмалыг эдээс 5см-ээс дээш гарсан, тухайн эдийн хэмжээнээс 10-20 дахин их байхаар тооцно.

Лабораторид амьд сорьц хүлээн авах шалгуур:

- Сорьцыг гурвалсан савлалтын зарчмаар тээвэрлэн авчирна.
- Амьд сорьц хийсэн савны гадна нүүрэн дээр үйлчлүүлэгчийн овог нэр, нас, хүйс, авсан эдийн нэр, төрлийг гаргацтай арилдаггүй маркераар бичих эсвэл ус нэвтэрдэггүй цаасан дээр бичсэн.
- Онош тогтоохоор авсан амьд сорьцыг хувааж таллахгүй бүтнээр нь эмгэг судлалын лабораторид илгээнэ.
- Сорьцыг өргөн уужим хоолойтой, сайн тагтай, цэвэр сав болон хуванцар саванд, мэс заслаар авагдсан том хэмжээний эд эрхтэнийг шингэн нэвчихгүй уут болон дэлгэж багтахаар саванд хийсэн байна.
- Эдийг муутахаас сэргийлэн бэхжүүлэх уусмал болох 10% формалинд заавал бэхжүүлсэн байхыг анхаарна уу.

Амьд сорьцын шинжилгээний хариу гарах хугацаа:

- Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг лабораторид хүлээн авсан амьд сорьцонд ажлын 5-8 хоногт онош дүгнэлт гаргана.
- Эсийн эмгэг судлалын сорьцонд ажлын 2-3 хоногт онош дүгнэлт гаргана.
- Мэс заслын явцад яаралтай хөлдөөн зүсэх шинжилгээ хийх тохиолдолд эмгэг судлалын лабораторид сорьц ирүүлснээс хойш 20-30 минутын дотор урьдчилсан дүгнэлт гаргаж илгээсэн эрүүл мэндийн байгуулагад утсаар мэдэгдэнэ.
- Иммунохистохими хийлгэх, эсвэл зөвлөх эмчийн зөвлөгөө авах тохиолдолд хариу гарах хугацаа хойшлодог.



Дараах тохиолдолд амьд сорьцыг буцаана:

- Нэр хаяггүй, илгээх бичиггүй, сорьцын мэдээлэл буруу
- Үйлчлүүлэгчийн мэдээлэл дутуу, мэдээлэл зөрсөн байх
- Тээвэрлэх, хадгалах нөхцөл нь буруу, асгарч гоожсон, задарсан, их хэмжээний өөх тос, бохирдол ихтэй
- Шаардлага хангаагүй сав, бэхжүүлэгч уусмалд хийсэн
- Сорьц тээвэрлэх журам зөрчсөн
- Түрхцийн шил хагарсан, шинжилгээг үнэлэх боломжгүй тохиолдол

Шингэн сорьцыг авсанаас хойш 2 цагаас илүү хугацаа өнгөрсөн

Эд хими (хистохими) шинжилгээний тухайд:

- Эд эсийн бүтцийн доторх химийн бүрэлдэхүүн уураг, нуклейн, хүчил, өөх, нүүрс төрөгч, фермент даавар, бичил биетэн, мөөг зэргийг будгийн өнгөөр болон тоо хэмжээгээр илрүүлдэг шинжилгээний арга юм. Дараах будгуудыг ашигладаг: Грамм, Гимз, АFB, Массон трихром, Вангизон, Тосон улаан, Эластик вангизон, ПАС, Альциан хөх зэрэг энгийн ба хосолмол будгуудыг ашиглаж байна.

Иммунохистохимийн шинжилгээний тухайд:

- Эсийн өвөрмөц уургийн бүрэлдэхүүн хэсэг эсрэгбие-эсрэгтөрөгчийн комплекс үүсгэн, хромоген ашиглан илрүүлэх зарчим дээр үндэслэсэн ялган оношлогооны арга юм.
- Иммуногистохимийн шинжилгээний хариу ажлын 5-8 хоногт гарна. Өвчний онош тодруулах зорилгоор нэмэлт шинжилгээ хийх шаардлагатай бол ажлын 5 хоногоор сунгаж онош, дүгнэлт гаргана.
- Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 49 А/118 тоот тушаалаар батлагдсан жишиг төлбөр тооцож авдаг.
- Иммунохистохимийн 101 нэр төрлийн урвалж бодис бодис ашиглан шинжилгээ хийж байна.